

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДОТООД АУДИТЫН 2022 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2022 оны 06 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, Гадаадын иргэн, харьяатын газрын Дотоод аудитын 2022 оны төлөвлөгөөг үндэслэн дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Төсөв, санхүүгийн чиглэлээр:

Байгууллагын дотоод аудитын 2022 оны төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр 2, нийцлийн чиглэлээр 3, нийт 5 удаагийн төлөвлөгөөт дотоод аудитын шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилвал:

| № | Хяналт, шалгалтын төрөл | Хамрагдсан байгууллагын нэр | Хяналт шалгалтын тоо | Тайлбар |
|---|---|-----------------------------------|----------------------|-------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр аудит | Захиргаа, удирдлагын газар | 1 удаа | Төлөвлөгөөт |
| 2 | | Дорноговь аймаг дахь газар | 1 удаа | Төлөвлөгөөт |
| 3 | Нийцлийн аудит /Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд/ | төв болон орон нутаг дахь газрууд | 2 удаа | Төлөвлөгөөт |
| 4 | | Дорноговь аймаг дахь газар | 1 удаа | Төлөвлөгөөт |

а) Байгууллагын даргын 2022 оны 10/02 дугаар удирдамжийн дагуу Захиргаа, удирдлагын газрын 2021 оны хүний нөөцийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, 03 дугаар сард 01/10/04 дугаартай илтгэх хуудсаар шалгалтын тайланг байгууллагын удирдлагад танилцуулав.

б) Байгууллагын даргын 2022 оны 10/03 дугаар удирдамжийн дагуу Дорноговь аймаг дахь газрын 2021 оны төсөв, санхүүгийн тайланд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, 05 дугаар сард 01-10/08 дугаартай илтгэх хуудсаар шалгалтын тайланг байгууллагын удирдлагад танилцуулсан.

Хоёр. Нийцлийн аудитын чиглэлээр:

а) Байгууллагын даргын 2022 оны 10/03 дугаар удирдамжийн дагуу Дорноговь аймаг дахь газрын даргын 2021 онд батлан гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, 05 дугаар сард 01-10/08 дугаартай илтгэх хуудсаар шалгалтын тайланг байгууллагын удирдлагад танилцуулав.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжүүдийн цахим хуудсан дахь хуулийн хэрэгжилт болон түүнийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх талаар байгууллагын даргын 2 удаагийн буюу 2022 оны 01-10/01 дугаартай удирдамжийн дагуу 2021 оны IV улирал, 01-10/04 дугаартай удирдамжийн дагуу 2022 оны I улиралд тус тус Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, 01-10/01, 01-10/07 дугаартай илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулан тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлэн мэдээллээр хангаж ажиллалаа.

Дотоод аудитын шалгалтын үр дүнг төв болон орон нутаг дахь газарт 4 удаагийн зөвлөмжийг нэгжийн даргын 2021 оны 09/11, 09/12, 2022 оны 10/15, 10/32 дугаартай дотоод албан бичгээр хүргүүлэн түүний биелэлтийг ханган ажилласан.

Гурав. Бусад асуудлаар:

Байгууллагын дотоод аудитын чиглэлээр 2021 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг 2021 оны 12 дугаар сард 03/23, байгууллагын 2021 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн тайланг 2022 оны 03/221 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын газраас тайлан мэдээ оруулах, үнэлгээ хийх албан хаагчид болон баталгаажуулах албан тушаалтны мэдээлэл ирүүлэх хүснэгтийн дагуу мэдээллийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр tumurochir@mojha.gov.mn цахим хаягаар хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1/1856 дугаартай “Зөвлөмж”-ийг 04 дүгээр сарын 22-ны өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд байгууллагын 2021 оны үнэлгээ, эрсдлийг танилцуулан хэлэлцүүлж, зөвлөмжийг зохион байгуулалтын нэгжүүдэд 10/30 дугаартай дотоод албан бичгээр хүргүүлж, 2022 онд эрсдлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөг 05 дугаар сарын 09-ний өдөр батлуулан зохион байгуулалтын нэгжүүдэд цахимаар хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын ерөнхий аудиторовын 2022 оны 266 дугаартай албан бичгийн дагуу Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020, 2021 онд хэрэгжүүлэх явцад зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийн болон үйл ажиллагааны тайлан, холбогдох баримт, мэдээллийг 04 дүгээр сард цахимаар хүргүүлэв.

Байгууллагын даргын 2022 оны 01/863 дугаартай дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналыг ирүүлэх тухай албан бичгийн дагуу 2022 оны 10/33 дугаартай дотоод албан бичгээр Санхүүгийн хэлтэст саналаа хүргүүлсэн.

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн нэг удаагийн хуралд оролцон үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлийн хугацаа дуусч, элэгдлээрээ балансын өртгөө нөхсөн актлах болон дахин ашиглах боломжтой хөрөнгийн жагсаалтад

хяналт тавин ажилласан байна. Байгууллагын даргын 2022 оны А/68 дугаар тушаалын дагуу нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах комисст ажиллав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
АУДИТЫН ХЭЛТЭС